

ГАРЧИГ

1	ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	3
2	БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	8
2.1	Судалгааны талбайн байршил	8
2.2	Судалгааны талбайн уур амьсгалын нөхцөл.....	9
2.3	Геологийн тогтоц ба геоморфологи	9
2.4	Гадаргын болон газрын доорх усны нөөц, горим, чанар	10
2.5	Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал, элэгдэл, эвдрэл, бохирдол	11
2.5.1	Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал	11
2.5.2	Хөрсний бохирдолт.....	12
2.5.3	Ургамлан бүрхэвч	13
2.6	Амьтны аймаг	14
2.7	Нийгэм-эдийн засгийн нөхцөл	14
3	ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	18
4	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	20
4.1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	21
4.2.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	22
4.3.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	23
4.4.	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр.....	25
4.5.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	26
4.6.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	27
5	ДҮГНЭЛТ	29

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Хүнд даацын машин механизмын тэвш угсрах цех, ажилчдын сууцны байгууламжууд.....	4
Хүснэгт 2. 000344780 газар ашиглах гэрчилгээтэй талбайн солбицол.....	9
Хүснэгт 3. Усны шинжилгээний үр дүн	10
Хүснэгт 4. Замын-Үүд сумын хүн амын тоо.....	14
Хүснэгт 5. Байгаль орчны шинжилгээ	18

Зургийн жагсаалт

Зураг 1. Хүнд машин механизмын тэвш угсрах цехийн технологийн схем	3
Зураг 2. Гааль дээрээс буусан хүнд даацын машин, механизм.....	4
Зураг 3. Хийн гагнуурын харагдах байдал.....	4
Зураг 4. Цех гадна талаас.....	5
Зураг 5. Баруун хаалга болон гагнуурын аппарат.....	5
Зураг 6. Ажилчдын байрны харагдах байдал.....	6
Зураг 7. Төслийн талбайн байршил, сансрын зураг.....	8
Зураг 8. Эзэмшил талбайд гаргасан гүний худаг	10
Зураг 9. Худгаас ирэх усыг хуримтлуулах сан болон ус цэвэршүүлэх систем...	11
Зураг 10. Төслийн талбайн бэлчээрийн төрлийн өнөөгийн төрх байдал	13
Зураг 11. Замын-Үүд сумын хүн амын өсөлт	15
Зураг 12. Сумдын хүн амын өсөлт.....	15

1 ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Тус төслийн үндсэн зорилго нь хилээр орж ирж буй хүнд даацын машин механизмыг угсрах, шалгах, холбогдох анхан шатны үзлэг, оношлогоо хийх, тээвэрлэлтийн даацад тохируулан ачих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх зорилготой юм.

Тус угсрах цех, ажилчдын байр төслийн үндсэн үйл ажиллагаа нь Замын-Үүд боомтоор орж ирж буй хүнд даацын машин механизмыг хүлээн авч, угсарч бусад төвүүд, захиалагч нарт нийлүүлэх, Замын-Үүд боомтод ойр орших захиалагч нарын хүнд даацын машин механизмд засвар үйлчилгээ үзүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Тус төслийн технологи ажиллагааны схемийг дараах зурагт үзүүлэв.



Зураг 1. Хүнд машин механизмын тэвш угсрах цехийн технологийн схем

Замын-Үүдийн боомт дээрээс хүнд даацын машин, механизмыг тээвэрлэн агуулахад буулган 3485 м² бүхий талбайд анхан шатны үзлэг хийнэ. Анхан шатны үзлэгээр машин, механизмын тос, тосолгооны материал хийх, бусад эд ангийн бүрэн бүтэн байдлыг тусгай удирдамжийн дагуу хянаж өөрөөр нь тээвэрлэх боломжтойг нь өөрөөр нь тээвэрлэх, боломжгүйг нь авто замыг даацад нийцүүлэн задлана.



Зураг 2. Гааль дээрээс буусан хүнд даацын машин, механизм

Хүнд даацын машины дугуй, тэвш, шанага болон бусад хэсгийг салган тусад нь ачдаг. Засвар үйлчилгээний ажилд АСП-10 маркийн хийн гагнуур ашигладаг.



Зураг 3. Хийн гагнуурын харагдах байдал



Тус хүнд даацын машин механизмын тэвш угсрах цех нь нийт 700 м² талбайд төлөвлөгдсөн.

Хүснэгт 1. Хүнд даацын машин механизмын тэвш угсрах цех, ажилчдын сууцны байгууламжууд

№	Барилга, байгууламж	Талбайн хэмжээ	Тоо хэмжээ
1	Хүнд машин механизмын угсралтын цех	23x18м	1
2	Ажилчдын модон сууц	18.5x15м	1
3	Гүний худаг	117 м гүн	1
4	Бохирын септик систем		1

Хүнд машин механизмын тэвш угсрах цех: Талбайн хойд хэсэгт 23:18 м харьцаатай дан давхар төмөр араг бүтээцтэй, сэндвичэн хүнд машин механизмын тэвш угсрах цех байрлана. Уг цехийн гэрэлтүүлэг, халаалтыг цахилгаан эх үүсвэрээс хангах бөгөөд цахилгааны дэд станцтай холбогдсон. Баруун болон зүүн талдаа 2 том хаалгатай бөгөөд дээврээс бэхлэгдсэн 5 тн даацтай 1 ш хөдөлгөөнт кран байрлуулсан. 2 эгнээ төмөр зам дээр нийт 4 тэргэнцэр байрлана. Гагнуур хийх үндсэн эд ангиудыг цехийн зүүн талын хаалган дээр тэргэнцэрт автокранаар өргөн тавьж дотогш оруулан гагнуурын ажил гүйцэтгэсний дараа баруун хаалгаар гарган мөн кранраар өргөж буулгана.



Зураг 4. Цех гадна талаас



Зураг 5. Баруун хаалга болон гагнуурын аппарат

Тээврийн хэрэгсэл ачих буулгах талбай: Хайрган хучилт бүхий талбайд тээврийн хэрэгслийг түр байрлуулна.

Ажилчдын байр: Талбайн баруун урд хэсэгт 18.5x15 м харьцаатай модон байшин байрлана. Дотроо усанд орох 2 өрөө, ариун цэврийн өрөөтэй, унд ахуйн усыг цэвэршүүлэх төхөөрөмж зэргээр тоноглогдсон байна.



Зураг 6. Ажилчдын байрны харагдах байдал

Эрчим хүч

Цахилгаан эрчим хүчний хэрэглээг өөрийн дизель цахилгаан эх үүсвэрээс хангадаг.

Усны хэрэглээ

Ус хэрэглээний нийт хэмжээ 1 хоногт 9.68 м³ буюу 0.11 л/с байна. Энэхүү усны хэрэглээг 60 м гүнтэй, ашиглах боломжит ундарга 1.2 л/с-тэй худгаас хангана.

2 БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2.1 Судалгааны талбайн байршил

“Барловорлд Монголиа” компанийн эзэмшлийн “000344780” тоот газар ашиглах гэрчилгээтэй “Хүнд машин механизмын тэвш угсрах цех, ажилчдын байр” төслийн талбай нь засаг захиргааны хувьд Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 3-р багийн нутагт, сумын төвийн хойд захад оршино. Улаанбаатар хотоос 650 км, аймгийн төв Сайншанд хотоос урагш 200 км зайтай.

“Барловорлд Монголиа” ХХК нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт, сумын засаг даргын 2017 оны 07-р сарын 19-ны өдрийн А/212 тоот захирамжаар 000344780 тоот газар эзэмших гэрчилгээгээр олгосон 1.5 га талбайд “Хүнд машин механизмын тэвш угсрах цех, ажилчдын байр” төслийг хэрэгжүүлж байна.

Засвар, техник үйлчилгээний хэсэгт 1 хоногт 1-3 машин, 7 хоногт 15-20 тээврийн хэрэгсэл болон хүнд машин механизмд хөдөлгүүрийн тос солих, явах эд ангийн засвар, хөдөлгүүрийн засвар, оношлогоо ба бусад үйлчилгээг үзүүлдэг.



Зураг 7. Төслийн талбайн байршил, сансрын зураг

Төслийн талбайн газар ашиглах гэрчилгээний солбицлыг дараах хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 2. 000344780 газар ашиглах гэрчилгээтэй талбайн солбицол

№	Х	Ү	Талбай, м ²
1	4846523.70	568103.97	15000
2	4846609.83	568155.94	
3	4846533.15	568284.94	
4	4846448.05	568232.33	

2.2 Судалгааны талбайн уур амьсгалын нөхцөл

Төсөл хэрэгжих талбай орчмын нутаг дэвсгэрийн агаарын жилийн дундаж температур 3.5 – 3.7°C байна. Жилийн хамгийн дулаан 7-р сарын дундаж агаарын температур 23.1 – 24°C юм. Үнэмлэхүй хамгийн их температур 41.5 – 41.6°C хүрч халсан бөгөөд энэхүү хамгийн их утгууд нь 1999 оны 7-р сарын 26, 28-ны өдрүүд, 2000 оны 7-р сарын 13-ны өдөр тус тус ажиглагдсан байна. Тус нутгаар 36.3 – 40.2°C-ийн үнэмлэхүй хамгийн их температур 5 %-ийн хангамжтай буюу 20 жилд 1 удаа тохиолдоно. Жилийн хамгийн хүйтэн 1-р сарын агаарын дундаж температур –15.3°C байна. Үнэмлэхүй хамгийн бага температур –41.4 – 41.5°C хүйтэрсэн байна. Төсөл хэрэгжих талбай орчмоор анхны цочир хүйтрэлт 9-р сарын 17-ны үед эхлэн, 5-р сарын 23-ны үед дуусна.

Төсөл хэрэгжих талбай орчмоор жилд унах хур тунадасны хэмжээ 100.9 – 113.5 мм байдаг. Зуны улиралд ихэнх хэсэг нь буюу 88 – 92 % нь унадаг бол хүйтний улиралд 10 % буюу 9.8 – 14.7 мм хур тунадас унадаг. 1 хоногт орсон хамгийн их хур тунадасны хангамжийн үзүүлэлтийг авч үзвэл 121 мм хур тунадас 1 %-ийн хангамжтай буюу 100 жилд 1 удаа, 80.5 мм хур тунадас 2 %-ийн хангамжтай буюу 50 жилд 1 удаа тус тус тохиолдоно.

Дорноговь аймгийн хэмжээнд салхины жилийн дундаж хурд нутгийн зүүн өмнөд хэсэгт харьцангуй бага 2.9 м/с, бусад хэсгээр 3.1 – 4.3 м/с байна. Жилийн явцыг авч үзвэл салхины хурдны их утга нь хавар, намрын улиралд ажиглагдаж 4 – 5.7 м/с, бага утга нь өвлийн саруудад ажиглагдаж 2.3 – 4.1 м/с байна. Салхины хамгийн их хурд 40 – 42 м/с, хүрсэн бөгөөд 15 м/с-ээс их буюу тэнцүү салхитай өдрийн тоо 1 жилд 35 удаа тохиолдоно. Баруун болон баруун хойд чиглэлийн салхи зонхилдог. Баруун чиглэлийн салхины давтагдал нийт нутгаар 12.1 - 47.7%, салхины дундаж хурд нь 5.2 – 6.9 м/с, хойд чиглэлийн давтагдал 11.3 – 40.6 %, салхины дундаж хурд 4.4 – 6.3 м/с байна.

2.3 Геологийн тогтоц ба геоморфологи

Судалгааны талбай орчмын районы геологийн тогтоц нь энгийн, хамгийн эртний чулуулаг нь дунд-дээд девоны ангилагдаагүй тунамал чулуулаг юм.

2.4 Гадаргын болон газрын доорх усны нөөц, горим, чанар

Судалгааны талбайн газрын доорхи усны онцлогийн талаар бичихдээ “Дунар-Од” ХХК-ийн 2010-2012 онд гүйцэтгэсэн “ӨМ-Дорнодын хэсэг орчмын гидрогеологийн 1:200000-ы зураглалын ажил, геоэкологийн иж бүрэн үнэлгээний ажлын тайлан”-аас авч ашиглав.

Төслийн талбай нь геологийн нийлмэл тогтоцтой, янз бүрийн нас, найрлагын гүний биетүүдээр зүсэгдсэн, хагарлын системүүдээр хэрчигдсэн блоклог бүтцийг бий болгосон байна. Мөн түүнчлэн физик газарзүйн нөхцлийн гол онцлог нь эрс тэс эх газрын уур амьсгалтай, унах хур тунадасны хэмжээ бага, ууршилт нь хур тунадаснаасаа давдаг, байнгын урсацтай гадаргын ус байхгүй, гадаргын хувьд үндсэндээ нэгэн хэвийн бууюу уулс хоорондын том, жижиг хотгор, хотос бүхий намхан бэсрэг уул, толгодтой юм. Эдгээр хүчин зүйлүүдээс хамааран газрын доорх усны байрлал, усан сүлжээ, тэжээгдлийн нөхцөл, химийн найрлага, тэдгээрийн тоо хэмжээ нь янз бүр байна.

Усны хэрэглээг гүний худагаас хангана. Худагаас ирэх усыг унд ахуйд хэрэглэнэ.



Зураг 8. Эзэмшил талбайд гаргасан гүний худаг

Худгийн координат: N 43° 45' 03.1" E 111° 50' 47.3"

Хүснэгт 3. Усны шинжилгээний үр дүн

Анион	1 дм ³ -д байгаа			катион	1 дм ³ -д байгаа		
	мг	мг-экв	мг-экв%		мг	мг-экв	мг-экв%
Cl ⁻	234,3	6,6	34,45	Na ⁺ + K ⁺	412,7	17,94	93,65
SO ₄ ⁻	60,0	1,25	6,52	Ca ²⁺	8,0	0,40	2,09
NO ₂ ⁻	0,0	0,0	0,00	Mg ²⁺	9,7	0,80	4,18
NO ₃ ⁻	0,6	0,01	0,05	NH ₄ ⁺	0,1	0,01	0,03
CO ₃ ⁻	42,0	1,40	7,31	Fe ²⁺	0,0	0,00	0,00
HCO ₃ ⁻	603,9	9,90	51,67	Fe ³⁺	0,2	0,01	0,06
Дүн	940,8	19,16	100,0	Дүн	430,7	19,6	100,0

Худгийн уснаас дээж авч ШУА-ын Газарзүй-Геоэкологийн хүрээлэнд шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээр газрын доорх ус нь гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн 1 төрлийн ус бөгөөд чанарын хувьд давсархаг, маш зөөлөн, сул шүлтлэг орчинтой ус байна. Шинжилгээний дүнгээр худгийн ус нь “Ундны усны чанарын стандарт MNS 900:2005” стандартад заасан хэмжээнээс нийт эрдэсжилт болон натрийн ионы агууламж нь их гарсан учир хүний унданд цэнгэгжүүлж хэрэглэх шаардлагатай байна.

Тус цехийн ажилчид унд ахуйд хэрэглэхдээ цэвэршүүлэн ашиглаж байна. Бид хээрийн судалгааны үед цэвэршүүлсэн уснаас мөн дээж авсан.



Зураг 9. Худгаас ирэх усыг хуримтлуулах сан болон ус цэвэршүүлэх систем

Дээжийг 1 л багтаамжтай цэвэр саванд 3 удаа зайлж авсан бөгөөд сэрүүн нөхцөлд 1 хоног хадгалан ШУА-ын Газарзүй-Геоэкологийн хүрээлэнд шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээр цэвэршүүлсэн ус нь цэвэршүүлээгүй худгийн устай ижил найрлагатай буюу муу цэвэрлэгдсэн байна.

2.5 Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал, элэгдэл, эвдрэл, бохирдол

2.5.1 Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал

Судалгааны талбайг бүхэлд нь хайргаар хучсан байсан учир хөрсний зүсэлтийг хашааны гадна талд хийж гүйцэтгэсэн. Заримдаг цөлийн ландшафт бүхий нутаг учир элсээр хучигдсэн гадаргатай байна.

Зүсэлт хийж, дээж авсан цэгийн байршил: N 43⁰ 45' 02,9" E 111⁰ 50' 49,7"
H=971м

Заримдаг цөлийн ба цөлийн хөрс	Гүн, см	Морфологийн бичиглэл
	А 0-11см	Цайвар хүрэн өнгөтэй, ургамлын нарийн үндэстэй, чулуугүй, өлөн чийгтэй, элсэнцэр, зарим газраар улаан толботой, НСI-ийн хүчилд сул буцална, шилжилт өнгөөр аажим, хил нь шулуун
	AB 11-42см	Бор шаргал өнгийн нарийн үелэл үүсгэсэн тогтоцтой, үндэс цөөн, ухахад дээд хэсгээрээ сийрэг, үеийн доод хэсэг нягтавтарт, хөнгөн шавранцар тоосорхог, бөөмөрхөг зарим хэсгээр хэврэг бөөмөрхөг бүтэц тохиолдно, НСI-ийн хүчилд сул буцална, шилжилт өнгөөр аажим хувирна, шилжилтийн хил шулуун.
	B 42-75см	Цайвар бор, нягт их, чийглэгдүү, дунд шавранцар, үндэсгүй, чулуугүй, цайвардуу өнгийн толбо, судал ихтэй, хавтанлаг бүтэцтэй, НСI-ийн хүчилд хүчтэй буцална, шилжилт өнгөөр аажим, шилжилтийн хил долгиорхог

Хөрсний урвлын орчин 7.8-8.0 буюу бүх үе давхаргад шүлтлэг шинжтэй. Цахилгаан дамжуулах чадвар сул 0.077-0.084 байна. Хөрсний шинж чанарын гол үзүүлэлт болох ялзмагийн хэмжээ дээд үед 1,04% байхад доод давхаргад 0,70% буюу ялимгүй багасах хандлагатай байгаа нь ургамлын үндэсний хуваарилалттай холбоотой. Ялзмагийн бодисын найрлагад фульво хүчлийн хэмжээ ямагт илүү байх тул ялзмаг нь гумат-фульво шинжтэй. Хөрс нь байнга карбонатлаг байдгаас хамаарахгүйгээр ялзмагийн хүчлүүдийн найрлагад R_2O_3 -ийн бүтэн хагас ислүүдтэй нэгдэл үүсгэдэг фракцийн хэмжээ давамгайлж ялзмаг нь хөдөлгөөнт шинжтэй байна. Хөрсний шингээх багтаамжийн хэмжээ бага (100 гр хөрсөнд 14-19,8 мг-экв), солилцоот сууриудын найрлагад кальци, магнион ион давамгайлж байна. Хөрсний усан тунгаамлын химийн найрлагаас харахад хялбар уусах давсны агууламж бага 0,04% байгаа нь заримдаг цөлийн ба цөлийн хөрсний шинж чанар юм.

Хөрсний дээд давхаргад янз бүрийн хэмжээтэй элс 4.8-6.1% эзлэх бөгөөд тоосны хэмжээ харьцангуй бага 1.2-2.4%, харин шаврын эзлэх хэмжээ тоосныхоос бага 2,0% байна. Доод давхаргуудад ширхэгийн бүрэлдэхүүний хэмжээ улам жижгэрч Bca давхаргад тоосны эзлэх хувь харьцангуй их байх бөгөөд мөн л шаврын эзлэх хэмжээ их буюу зүсэлтийн хэмжээнд хамгийн бага агуулга 1.6 % байна. Задлан шинжилгээний дүнгээс харахад элсэнцэр механик болон шаврын бүрэлдэхүүн хөрсний бүх үе давхаргуудад зонхилж байгаа бөгөөд доошлох тусам физик шаврын эзлэх хэмжээ нэмэгдэж байгаа нь хөрсөн дэх өгөршил, шавар үүсэх үйл явцтай холбоотой метаморф шинжийн илрэл болно. Чулууны нийт массын 18.9% нь сайр, жижиг хэмжээтэй мөлгөржөөгүй чулуу зонхилж байна.

2.5.2 Хөрсний бохирдолт

Эдэлбэр газрын хөрсний бохирдлыг тодорхойлох зорилгоор хөрсний зүсэлт хийсэн 1 цэгээс дээж авч хром, никель, хар тугалга, цайр, кадми зэрэг хүнд металлын агууламжийг “Инженер Геодези” ХХК-ийн Хөрс судлалын лабораторид 5 үзүүлэлтээр задлан шинжилгээ хийлгэв.

Тус талбайн хөрсөнд шинжлүүлсэн элементүүдийн агууламж нь “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008” стандарттай харьцуулбал *зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу стандарт хэмжээнд* байна.

2.6 Ургамлан бүрхэвч

Судалгааны талбайн эргэн тойронд ургамал нөмрөгт өөрчлөлт орсон. Ургамлын арвийн үнэлгээний хувьд дэд зонхилогч ургамлууд нь сор1, бусад зүйл ургамлууд нь sp-sol үнэлгээтэй байна. Ерөнхий тусгаг бүрхэцийн ихэнх хувийг ганц наст өвслөг ургамлууд бүрдүүлж, тэдгээрийн 2-р ташингын сөөгөнцөрлөг ургамлын хагд ба борог өвс бүрдүүлж байлаа. Ургамлын ташинга үүсгэх байдлаар нь үзвэл сөөг, сөөгөнцөрлөг ургамал дээд дэд, олон наст өвслөг, ургамал дунд дээд, өнгөрсөн жилийн борог өвс, хагд (найлзуурууд) доод дэд ташингийг бүрдүүлж байна.



Зураг 10. Төслийн талбайн бэлчээрийн төрлийн өнөөгийн төрх байдал

Харганат бэлчээрийн зонхилогч зүйл *Caragana stenophylla*-нарийн Харгана, *Caragana leucophloea*-алтан Харгана, *Stipa gobica*-говийн Хялгана зүйл бүрдүүлж байна. Дэд зонхилогч *Artemisia xerophytica*-хуурайсаг Шарилж, *Allium polyrrhizu*-таана, *Bromus inermis*-соргүй Согоовор зэрэг зүйлүүд бүрдүүлж байна. Үүний зэрэгцээ *Artemisia pectinata*-өмхий Шарилж, *Eragrostis minor*-бага Хургалж, *Chloris virgata*-саваан Булган сүүл, *Setaria viridis*- ногоон Хоног будаа, *Carex duriuscula*-ширэг Улалж зэрэг ургамлууд зонхилон ургасан. Энэхүү бүлгэмдлийн өнөөгийн төлөв байдал дунд зэрэг доройтолд орсны улмаас уг бүлгэмдэл флорын баялагаараа ядмаг болсон байна. Тухайн бэлчээрт доройтлыг илэрхийлэгч ургамлууд зонхилсон байна. Бэлчээрийн төрлийн дундаж өндөр 25см, ерөнхий тусгаг бүрхэц 39.5 хувь, зонхилогч болон дэд

зонхилогч зүйл ургамлууд сор1 арвийн үнэлгээтэй. Судалгааны талбайн 2га талбайг бүрдүүлж байна. Бэлчээрийн ургац 150кг/га байх ба түүний 50%-ийг ганц наст эзлэж байна.

2.7 Амьтны аймаг

Төслийн талбай орчмын нутаг дэвсгэр нь амьтны аймгийн хувьд төдийлөн ядмаг биш ч төсөл хэрэгжиж буй талбай нь сумын төвд байрлах учир амьтад үргэн дайжиж, суурин газрын цөөн зүйл амьдрах ажээ.

Монгол орны амьтны аймгийн мужлалтын зургаас (Зураг 8) харахад судалгааны талбай нь Хойд говийн тойрогт багтаж байна. Энэ нь төслийн нутагт хээрийн бүсийн амьтан нэвтрэн орж ирэх боломжтой, урдаас хойш нүүх нүүдлийн зарим зүйл шувуу бууж амрах, дамжин гарах нутаг байж болохыг харуулж байна.

Амьтан судлаачдын бүтээлд (Ашигласан материалын жагсаалт) тус нутагт тэмдэглэсэн зүйлүүд, нутгийн хүмүүсийн өгсөн ам мэдээ болон ажиглалтын дүнг нэгтгэн төслийн талбай болон орчны бүс нутагт 5 зүйл мөлхөгч, 19 зүйл шувуу, 16 зүйл хөхтөн амьтан тэмдэглэлээ. Эдгээр амьтны бүрдлийг анги тус бүрээр амьтны аймгийн ангилал зүйн дарааллаар доор дэлгэрэнгүй авч үзэв. Ангийн нэрийг шинжлэх ухааны, монгол, англи нэр гэсэн дарааллаар бичив.


2.8 Нийгэм-эдийн засгийн нөхцөл

Нийгмийн үзүүлэлт


Судалгааны талбайн орших Замын-Үүд сумын хүн амын тоо 2017 оны байдлаар 18241 хүн байна. Замын-Үүд сумын хүн амын өсөлтийг аймгийн хүн амын өсөлттэй харьцуулахад хоорондоо шугаман хамааралтай байна. Замын-Үүд сумын хүн амын өсөлт бусад сумтай харьцуулахад хамгийн өндөр буюу 4.63% байна.

Хүснэгт 4. Замын-Үүд сумын хүн амын тоо


Үзүүлэлт	2014	2015	2016	2017
Сумын хүн амын тоо, хүн	16306	15702	17519	18241
Аймгийн хүн амын тоо	63492	63125	66606	68192
Аймгийн хүн амын тоотой харьцангуй хувь	25.7	24.9	26.3	26.7



Зураг 11. Замын-Үүд сумын хүн амын өсөлт



Аймгийн хүн амтай харьцангуй хувь хэмжээ



Зураг 12. Сумдын хүн амын өсөлт

Суурин хүн амын 50.0 хувь нь эрэгтэйчүүд, 50.0 хувь нь эмэгтэйчүүд юм. Нийт хүн амын 63.1 хувь нь хот (аймгийн төв), тосгонд, 13.7 хувь нь сумын төвд, 23.2 хувь нь хөдөөд амьдарч байна. Хот тосгонд амьдарч буй хүн амын тоо өмнөх оноос 0.7 пунктээр, сумын төвд амьдарч буй хүн амын тоо 0.4 пунктээр, хөдөөд

амьдарч буй хүн амын тоо 0.2 пунктээр тус тус буурчээ. 109.4 мянган кв.км нутаг дэвсгэрт 68.2 мянган хүн ам оршин суудаг бөгөөд 1 кв.км нутаг дэвсгэрт 0.62 хүн ногдож байна. Замын-Үүд, Сайншанд, Даланжаргалан сумын хүн амын нягтрал аймгийн дунджаас дээгүүр байна.

2017/2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 22 сургуульд 12759, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 597, АШУҮИС-д 627 бүгд 13983 оюутан, сурагч суралцаж байна. Энэ нь өмнөх оноос 2.9 хувиар буюу 397-оор илүү байна. 2017/2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид 1553, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд 141, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвд 360 оюутан, сурагч шинээр элсэн суралцлаа.

Аймгийн соёл урлагын байгууллагууд 2017 онд 30.0 мянган хүнд үйлчилж, 40476.2 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ. Аймагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн урлагийн байгууллага 165 удаагийн тоглолт хийж, музейнүүд дотоод, гадаадын 4.8 мянган хүнд үйлчилсэн байна.

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2017 оны эцэст 1025 болсны 965 (94.1%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 60% нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнө оны мөн үеийнхээс 478 хүнээр, өмнөх сараас 153 хүнээр тус тус буурсан байна.

Эдийн засгийн үзүүлэлт

2017 оны 12-р сарын байдлаар орон нутгийн төсөвт 24516.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 100% байна. Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн орлогын 77.5%-ийг татвар, 22.5%-ийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 5189.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 1885.9 сая төгрөгөөр, төлөвлөгөөнөөс 1314.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 2001.6 мянган толгой мал тоологдсоны дотор 40.7 мянган тэмээ, 133.2 мянган адуу, 72.6 мянган үхэр, 861.5 мянган хонь, 893.6 мянган ямаа тоологджээ. Нийт малын тоо 14.2%-иар өссөн байна.

Сүргийн бүтцэд ямаа 44 тэмээ 2.0 хувийг тус тус эзэлж байна. пунктээр өсч, тэмээ, адуу, хонины хувь өмнөх оны мөн үетэй адил байна. Аймгийн хэмжээгээр 1000 өрхөөр өсчээ. 1000-аас дээш малтай Дэлгэрэх суманд 40, Даланжаргалан суманд тоологдсон нь хамгийн олон нь байсан бол 200 Дэлгэрэх суманд 4 өрх,

Иххэт суманд 3, Алтанширээ, Эрдэнэ сумдад тус бүр аминдаа малтай 5201 улирлын туршид малаа маллаж нэг өрхөд 379 толгой мал ногдож байгаа нь 201 толгой, малтай нэг өрхөд ногдох онд 7232 болж өмнөх оноос 245 (3.0%), 2017 онд оны эхний нийт хээлтэгч малын 643.0 төлийн 655.3 (99.6%) мянган төл 26.5 хувиар өссөн байна.

Энэ онд 51 худаг шинээр гаргахад 96.6 сая төгрөг зарцуулсан байна. Малжуулах арга хэмжээнд хувь нь бог мал байв. Малжуулалтанд хамрагдсан өрхийн тоо буурч, нэг өрхөд дунджаар 71 нэмэгдсэн үзүүлэлт байна.

Аж үйлдвэрийн салбарт оны эхний 12 сард оны дүнгээр 162252.1 сая.төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 273507.2 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнө онтой харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 4.5 дахин, борлуулалт 5 дахин өслөө. Үүнд уул уурхайн олборлолт, цементийн үйлдвэрлэл, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 70619.0 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

3 ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Засвар, техник үйлчилгээний хэсэгт 1 хоногт 1-3 машин, 7 хоногт 15-20 тээврийн хэрэгсэл болон хүнд машин механизмд хөдөлгүүрийн тос солих, явах эд ангийн засвар, хөдөлгүүрийн засвар, оношлогоо ба бусад үйлчилгээг үзүүлдэг.

“Эко Хайрхан” ХХК-ийн мэргэжилтэн, экспертүүд хээрийн судалгааны ажлыг нөлөөллийн бүсийн дотор хийж гүйцэтгэв /Хээрийн судалгааны үр дүнг тус төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлангаас үзнэ үү/.



Хүснэгт 5. Байгаль орчны шинжилгээ

№	Байгаль орчны шинжилгээ хийх асуултууд	Тийм	Үгүй
Ландшафтын бүрдэл хэсэг болон усан орчин, химийн бодисын хэрэглээний нөлөөлөл			
1	Газрын гадаргын хэв шинжид гарах өөрчлөлт	+	
2	Газар ашиглалтын өөрчлөлт	+	
3	Төсөл хэрэгжүүлэх зориулалтаар усны нөөцийг ашиглах эсэх	+	
4	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх эсэх		+
5	Үл нөхөн сэргэх болон байгалийн ховор нөөц, баялгийг ашиглах эсэх		+
6	Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа явагдах эсэх	+	
7	Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг үйлдвэрлэх үйл ажиллагаа явагдах эсэх		+
8	Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд хатуу хог хаягдал гарах эсэх	+	
9	Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд шингэн хаягдал /бохир ус/ гарах эсэх	+	
Орчны бохирдол			
10	Хөдөлгүүрийн хөргүүрийг солих үед хөргөгч шингэн алдагдах	+	

	эсэх		
11	Дугуйны хаягдал үүсэх эсэх	+	
12	Ашигласан тосыг тусгай зориулалтын талбайд хадгалдаг эсэх		+
13	Ашигласан тосыг шатаадаг эсэх		+
14	Хаягдал тосны шүүлтүүрийг дахин ашигладаг эсэх		+
15	Дугуй, ашигласан тос, тосны шүүлтүүр гэм мэт хаягдлыг талбай дээр нь устгадаг эсэх		+
16	Аккумуляторын хаягдлыг талбайд дээр устгадаг эсэх		+
17	Аюултай шинжтэй хог хаягдлыг Монгол улсын Засгийн газрын 264-р тогтоолын дагуу ангилан ахуйн шинжтэй хог хаягдлаас тусад нь хадгалдаг эсэх		+
Эрсдэлийн үнэлгээ			
18	Хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд үүсэх эрсдэл	+	
19	Байгаль орчинд үүсэх эрсдэл	+	

4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчин-эдийн засаг

Энэхүү төслийн үйл ажиллагаа нь МУ-ын ЗГ-ын мөрийн хөтөлбөр, Бүс нутгийг хөгжүүлэх бодлого, засаг захиргааны нэгжийн хөгжлийн хөтөлбөр, эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичигт тусгагдсан үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулна. Улс орны эдийн засагт дараах хэлбэрээр хувь нэмэр оруулна.

- Ашгийн татвар
- Хүн амын орлогын албан татвар
- Нийгмийн л шимтгэл
- Газар ашигласны төлбөр
- Ус ашигласны төлбөр
- Байгалийн нөөц баялаг ашиглахгай холбогдох татвар, төлбөрүүд

Мөн байгаль орчныг хамгаалах зардлыг жил бүр үндсэн үйл ажиллагааны төсөвт тусгаснаар БОХТ ба ОХШХ-т тусгагдсан арга хэмжээнүүд хэрэгжинэ.

Байгаль орчин-удирдлага зохион байгуулалт

Төсөл хэрэгжүүлэгч “Барловорлд Монголиа” ХХК нь байгаль орчны мэргэжилтэн эсвэл мэргэжлийн байгууллагатай гэрээлэн ажиллана. Ингэснээр байгаль орчны календарьчилсан төлөвлөгөө гаргаж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компанийн удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

Байгаль орчны бодлого, зорилго

“Барловорлд Монголиа” ХХК нь экологи-эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх байгаль орчны бодлогоо дараах хэлбэрээр тодорхойлсон.

- Компанийн бүхий л үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах асуудал нь чухал ач холбогдолтой байна.
- Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх, байгаль орчны үзүүлэлтүүдийг сайжруулах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчинд учруулах нөлөөллүүдийг хүрч болох хамгийн бага түвшинд байлгахгаар хянана.
- Компаний байгаль орчны бодлого, зорилт, хэрэгжилт, тэдгээрийн үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байна.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах хууль, журам, стандарт
Аюултай хог хаягдал болон ахуйн хог хаягдал түр хадгалах цэгийн орчныг хатуу хучилттай болгох	Газрын доорх ус, хөрсний чанар	м ²	9	15	135	Хөрс хамгаалах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Усны тухай хууль
Шатах тослох материалын бохирдлоос урьдчилан сэргийлэх, бохирдсон үед бохирдсон хөрсийг хуулж авах, саармагжуулах	ШТМ-иар хөрс, ус бохирдох	Иж бүрэн	1	-	-	Хөрс хамгаалах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Усны тухай хууль
Нийт зардал					135.0	

4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	- Тэрбум мод үндэсний хөдөлгөөн - Эзэмшил талбайн 10%-аас доошгүй талбайд ногоон байгууламж бий болгох	500ш мод тарих	Өөрийн эзэмшил талбайд	ш	500	1.5	1250.0	5, 10 сар	Хөрс хамгаалах, цөлжилтөс сэргийлэх тухай хууль, Газрын тухай хууль Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
2		Тарьсан мод, сөөгийг арчилж ургуулах, зүлэгжүүлэх		ш	500	1.0	300.0	5-10 сар	
3	Нийт, мян.төг						1550.0		

4.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
2	Ердийн	Үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг боломжит бүх төрлөөр ангилан хадгалж байх. - Төмрийн хаягдал - Цаасны хог хаягдал - Хуванцар хаягдал - Тостой хаягдал - Ерөнхий хаягдал - Хоол хүнсний хаягдал - Шатах тослох материалын хаягдал	Бүх хог хаягдал	-	-	-	-	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
3		Энгийн хог хаягдлыг ТҮК-тай гэрээгээ сунган гэрээний дагуу зайлуулж байх	Хог хаягдлын хуримтлал	Удаа	-	12	Гэрээний дагуу	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль MNS 5344:2011
4		Ахуйн бохир усыг “Ухаа худаг” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу зайлуулж байх	Шингэн хог хаягдал	Удаа	-	4	Гэрээний дагуу	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль
5		Хоол хүнсний хаягдлыг бокаши бордоо болгох	Хөрс бохирдох	Иж бүрэн	44.0	1	44.0	2-р улирал	Хог хаягдлын тухай хууль
6		Аюултай	Ашигласан тос түр	Хөрс	ш	-	2	Ашигласан	1-р улирал

	хог хаягдал	хуримтлуулах битүүмжлэл сайтай, агууржуулалтын системтэй сав байрлуулах	бохирдох				боошиг байж болно		тухай хууль
7		Хаягдал аккумулятор, тос, тосолгооны материал, тостой даавуу гэх мэт аюултай хог хаягдлыг УБ хотод төв оффист хүргүүлэн мэргэжлийн байгууллагаар устгуулах	Аюултай хог хаягдлын нөлөөлөл	удаа	Гэрээний дагуу	4	Гэрээний дагуу	Улирал бүр	
	Нийт, мян.төг						44.0		

4.4. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар	Тоосонцор: TSP, PM2.5, PM10 SOx NOx COx Дуу шуугиан	- Ажилчдын байр - Засварын газар - Хашаанд салхины чиглэлийн доор	Жилд 1 удаа	-	Өөрийн багажаар	MNS 4585:2016 Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
Хөрсөн бүрхэвч	- Агрохими - Хүнд металл /Pb, Cd, Hg, As, Cr,.../ - Нефтийн бүтээгдэхүүн - Бактереологи	- Хаягдал тос хадгалах талбай - Засварын газрын хашаа	Жилд 1 удаа	55.0	110.0	MNS 5850:2008
Ус	- Хүнд металл - Анион, катион - Бактереологи	- Худгийн ус - Ундны цэвэршүүлсэн ус	Жилд 1 удаа	96	192.0	MNS 900:2018 Усны тухай хууль
Нийт зардал, мян.төг					302.0	

4.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь, сар												Хариуцсан албан тушаалтан	Тайлбар	
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12			
1	Тухайн жилийн БОМТ-г БОАЖЯ-р батлуулах	-														БО-ы мэргэжилтэн	БОНБУ-ий тухай хууль
3	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг Дорноговь аймгийн БОГ-т хүргүүлж, дүгнүүлэх	-														БО-ы мэргэжилтэн	БОНБУТ хууль, БОАЖ-ын сайд А/618
4	Ус ашиглуулах дүгнэлтийг Дорноговь аймгийн байгаль орчны газраар гаргуулах	50														БО-ы мэргэжилтэн	Усны тухай хууль
5	Сумын ЗДТГ-тай Ус ашиглах гэрээ байгуулах, эрхийн бичиг авах	-														Захирал	Усны тухай хууль
6	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлыг бууруулах, хөдөлмөр хамгаалал, галын аюул, осол эрсдлийг бууруулах сургалтыг зохион байгуулах	50.0														БО-ы мэргэжилтэн	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
7	Нийт зардал, мян.төг	100.0															

4.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ. Тус хэлэлцүүлгийг жил бүр 10-р сард зохион байгуулах ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд хэлэлцүүлгийн үр дүнг оруулна.

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагна х зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	Төслийн талбайн ойролцоох иргэд болон төсөл хэрэгжиж буй баг, сонирхогч талууд, засаг захиргааны ажилчид	Цаасан болон presentation хэлбэрээр тайлагнах, хэлэлцэх	Үйл ажиллагааны талаарх мэдээлэл, төслөөс БО болон нийгэм эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах багасгах чиглэлээр хийсэн арга хэмжээ, байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажлын тухай	10 сард	50.0	Захирал, менежер, БО-ы мэргэжилтэн	Замын-Үүд сум, ИНХ
2	БОМТ-ий биелэлтийг аймгийн БО-ы газраар дүгнүүлэх	3% хэвлэмэл болон цахим хэлбэрээр	Тухайн жилийн БОМТ-ий хүрээнд, мөн байгаль хамгаалах чиглэлээр хийсэн нэмэлт ажлуудын тухай	11 дүгээр сарын 1	-	Захирал, менежер, БО-ы мэргэжилтэн	Дорноговь аймгийн БОАЖГ
3	Нийт зардал, мян.төг				50.0		

Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал

№	Арга хэмжээ	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө	135.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1550.0
3	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	44.0
4	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	100.0
5	Орчны хяналт шинжилгээ	302.0
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	50.0
	Нийт зардал, мян.төг	2180.0

5 ДҮГНЭЛТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутагт орших “Хүнд даацын машин механизмын засвар, үйлчилгээний төв” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2019 онд батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан хийж гүйцэтгэв. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 2180.0 мян.төг (хоёр сая нэг зуун наян мянган төгрөг) болно.